



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Монгол секюритиес” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2018 оны 7-р сарын 04-ний өдрийн 13 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, 22-р БААЗ ХК-ийн байранд эхэллээ.

Хуралд : Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Л.Гүндэгмаа, А.Баатаржав, Т.Эрдэнэбаатар, З.Номундарь, П.Эрдэнэчулуун, Т.Зоригтбаатар, Б.Баярсайхан болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга П.Эрдэнэчулуун нар оролцов.

Хурлыг Л.Гүндэгмаа удирдав.

Хурлаар:

Компанийн тухай хуулийн 69.3 Энэ хуулийн 69.1-д заасан хувь хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг төлөөлөн удирдах зөвлөл товлон бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

Үүнд:

- Хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
- Хурлын хэлэлцэх асуудал;
- Хувьцаат компанийн хувьд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
- Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
- Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
- Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
- Хурлын дарга, тооллогын комиссын дарга, гишүүд.

СОНССОН НЬ:

Б.Баярсайхан: Хойшлогдсон ээлжит бус хурлыг ажлын 20 хонгийн дотор хуралдуулах хуулийн заалттай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 07 дүгээр сарын 28-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, “22-р БААЗ” ХК-ийн байранд 201 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

- Компанийг дахин хөрөнгөжүүлэх тухай.
- Бусад.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 06 дүгээр сарын 13-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2018 оны 07 дугаар сарын 19-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Баярсайхан/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

6. Ээлжит бус хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

8. Компанийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2018 оны 06 сарын 22-ны өдрийн 14 цагаар тасалбар болгосугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Б.Баярсайхан дарга
- Ю.Туяацэцэг гишүүн
- З.Оюунбилэг гишүүн

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Б.Баярсайхан/-т даалгасугай. .

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Монгол секюритиес ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Баярсайхан/-д даалгасугай.

: Төлөөлөн Удирдах Зөвлөл энэ удаа хэлэлцэн шийдвэрлэхээр төлөвлөсөн асуудлаа бүгдийг хэлэлцэн шийдвэрлэсэн учраас хурлын ажиллагаа дуусгавар болж байна. Хурлыг 14 цаг 10 минутанд хаалаа.

ТУЗ- ИЙН ДАРГА

ГИШҮҮД



З.НОМУНДАРЬ

Т.ЭРДЭНЭБААТАР
Л.ГҮНДЭГМАА
Т.ЗОРИГТБААТАР
П.ЭРДЭНЭЧУЛУУН
Б.БАЯРСАЙХАН
А.БААТАРЖАВ
К.ЮУЖИРО

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

З.ОЮУНБИЛЭГ